



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.06.11-06.15

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын компаниудын хувьцааны ханш өөр өөр үзүүлэлттэй хаагдлаа. S&P 500 индекст багтдаг өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш өссөн бол эрчим хүч, банк санхүү, аж үйлдвэрийн салбарын компаниудын хувьцааны ханш унажээ.

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп болон БНАСАУ-ын удирдагч Ким Чен Ун нарын уулзалт зах зээлийн ханшид нөлөө үзүүлээгүй байна. Энэ нь Хойд Солонгосын төрийн тэргүүн Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй болгох шийдвэрийг уулзалтаас өмнө эцэслэн гаргасантай холбоотой ажээ.

АНУ-ын Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар нэмэгдүүлж, хоёр хувь болгосон явдал зах зээлийн индекст ихээхэн нөлөө үзүүллээ. Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ энэ онд дахиад хоёр удаа буюу нийт 4 удаа нэмнэ гэсэн хүлээлт зах зээлд сөргөөр нөлөөлөв.

Энэ долоо хоногт АНУ-ын Хөдөлмөрийн яамны мэдээлсэнээр 5-р сард инфляцийн түвшин 2011 оноос хойшхи хамгийн дээд түвшин буюу 2.8 хувьд хүрчээ. Үүнд газрын тосны үнийн өсөлт илүү нөлөөлсөн байна.

Голлох жижиглэнгийн худалдаа 5-р сард 0.6 хувиар өсөв. Хэрэглээний түвшин орлогын түвшинээс илүү нэмэгдсэн нь зээлийн хэрэглээг нэмэгдүүлжээ.

АНУ нь 50 тэрбум ам.доллартай тэнцэх БНХАУ-ын импортын бараа бүтээгдэхүүнд тариф тогтоохоор шийдвэрлэв. БНХАУ тус арга хэмжээнд АНУ-ын бараа бүтээгдэхүүнд тариф тогтоох болохоо мэдээлсэн билээ.

Европ: Энэ долоо хоногийн сүүлээр Европын компаниудын ханш АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудал хүндэрсэнтэй холбоотойгоор буурчээ.

Европын Төв банк 9-р сарыг дуустал сард 30 тэрбум еврогийн бонд худалдан авах хөтөлбөрөө үргэлжлүүлээд он дуустал 15 тэрбум евро болгон бууруулж, оны эцсээс бонд худалдан авах хөтөлбөрөө зогсоох талаар мэдэгджээ. Ингэхдээ бодлогын хүүг 2019 оны хагас хүртэл одоогийн түвшинд хадгалахаар төлөвлөж байгаа аж. Энэхүү шийдвэрийг гаргасны дараа еврогийн ханш ам. долларын эсрэг суларсан байна.

Япон: Японы компаниудын хувьцааны ханш өсөлттэй хаагдлаа. Иений ханш ам.долларын эсрэг 110.6 нэгж хүрсэн нь 2017 оны эцсээс 2%-аар чангарсан байна.

Япон улсын ажиллах хүчний хомсдол үүсэж байгаатай холбогдуулан тус улсын Засгийн газар гадаадын иргэдэд зориулсан 5 жилийн хугацаатай ажлын зөвшөөрөл олгож эхлэхээр төлөвлөж байна. Тус бодлогын хүрээнд Япон улс хөдөө аж ахуй, барилга, зочид буудал, усан онгоц үйлдвэрлэл, нийгмийн халамжийн салбарт 500 мянган гадаад иргэнийг ажиллуулах ажээ.

Японы төв банк 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын өгөөжийн тэг орчим хувьд барин, богино хугацааны бодлогын хүүг -0.1 хувь байлгах зорилгоор Засгийн газрын бондыг жилийн 80 тэрбум иенээр худалдаж авсаар байхаа мэдээлжээ.

БНХАУ: БНХАУ-ын голлох индексүүд худалдааны маргааны асуудал хүндэрсэнтэй холбогдуулан 2016 оноос хойшхи хамгийн доод түвшинд хүрлээ. 50 тэрбум ам.доллартай тэнцэх БНХАУ-ын импортын бараа бүтээгдэхүүнд тариф ногдуулсан АНУ-ын шийдвэрийн дараа Хятадын компаниудын хувьцааны ханш унав. Мөн АНУ нь тариф ногдуулах 100 тэрбум ам.доллартай тэнцэх Хятад улсын импортын бараа бүтээгдэхүүний хоёр дах жагсаалтыг бэлдсэн ажээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,824.22	1.03% ▲
Dow Jones	АНУ	25,090.48	-0.89% ▼
S&P 500	АНУ	2,779.66	0.02% ▲
Nasdaq	АНУ	7,746.38	1.32% ▲
S&P/TSX	Канад	16,314.42	0.69% ▲
FTSE 100	Их Британи	7,633.91	-0.61% ▼
S&P/ASX 200	Австрали	6,094.00	0.81% ▲
Nikkei 225	Япон	22,851.75	0.69% ▲
Hang Seng	Хонг Конг	30,309.49	-2.10% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	109.40
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	96.23
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	95.50
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	112.72
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.07
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.57
TDBM' 2020	USD	9.3%	106.13

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.085	0.04 ▲
Libor 3M	2.326	0.00 ▼
Libor 6M	2.504	0.02 ▲
Libor 1YR	2.772	0.03 ▲
US 6M Bond	2.056	-0.04 ▼
US 2YR Bond	2.541	0.04 ▲
US 3YR Bond	2.666	0.02 ▲
US 5YR Bond	2.787	0.00 ▼
US 10YR Bond	2.910	-0.04 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.06.15	Өөрчлөлт
USD	2,418.64	0.24% ▲
CNY	377.07	0.18% ▲
EUR	2,803.32	-1.36% ▼
RUB	38.52	0.05% ▲
KRW	2.21	-1.34% ▼
JPY	21.89	-0.77% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,278.94	-1.56% ▼
Мөнгө /spot/	16.57	-1.19% ▼
Зэс	313.60	-4.97% ▼
Нүүрс	110.82	1.16% ▲
WTI газрын тос	64.38	-1.86% ▼
Brent газрын тос	73.44	-3.84% ▼
Байгалийн хий	3.03	3.41% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018.IV	6.00%
Бодлогын хүү	2018.IV	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018.IV	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018.IV	12.80%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018.IV	5.30%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018.IV	19.30%
Зээлийн дундаж хүү /валют/	2018.IV	10.20%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 46 компанийн 752.2 сая төгрөгийн 5,257,132 ширхэг хувьцаа арилжигдав.

"Алтайн зам" /AZH/ компанийн хувьцаа 100.91%-аар буюу хамгийн ихээр өсч 8,565 төгрөгт хүрч хаагдсан бол "Монгол секюритиес" /MSC/ компанийн хувьцаа 21.21%-аар буурч 650 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 17,220 ширхэг үнэт цаас 1,798.2 сая төгрөгөөр арилжаалагджээ.

Компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр арилжаа явагдаагүй байна.

6-р сарын 15-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,464.6 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,824.22 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.03%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: MSE

Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: MSE

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	2,696.5
Зах зээлийн үнэлгээ	2,464,577.7

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,824.22	1.03% ▲
MSE I индекс	9,582.09	1.16% ▲
MSE II индекс	9,936.84	1.10% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	4,380,922	251,932,624
Говь	10,416	243,872,980
Монгол базальт	388,604	148,296,435
АПУ	241,542	141,165,001
Таван Толгой	3,775	37,871,300

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Алтайн зам	8,565.00	100.91% ▲
Хөвсгөл алтан дуулга	187.12	32.24% ▲
Баялаг налайх	311.00	31.92% ▲
Хай Би Ойл	65.94	13.69% ▲
Хөх ган	95.00	11.11% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол секюритиес	650.00	-21.21% ▼
Ноёт хайрхан	1,125.00	-14.90% ▼
Дархан хөвөн	12,000.00	-14.29% ▼
Монголын хөгжил үндэсний нэгдэл	5,200.00	-11.86% ▼
Ремикон	40.12	-4.48% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	3,903,270,413
БиДиСек	535,981,467
Стандарт Инвестмент	144,580,701
Гаули	107,680,560
ТиДиБи Капитал	107,078,965

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	594.85	633,028
Таван толгой	10,000.00	526,652
МИК	10,500.00	217,448
Говь	23,500.00	183,326
Сүү	216.15	74,356

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-06/06/19-A0254-15.49	10,820	1,120,356,900	103,090	104,000	104	15.490%
2	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	6,400	677,888,000	104,560	107,280	156	15.140%

Компанийн бондын хоёрдогч зах зээл

№	Name	Volume	Turnover /MNT/	Minimum /MNT/	Maximum /MNT/	Weeks	Annual interest rate
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр	Хуваарилах хэлбэр
1	ERS	Монгол алт ХК	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
2	TEE	Тээвэр дархан ХК	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
3	TTL	Таван Толгой ХК	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
4	EER	Ариг гал ХК	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с	Тодорхойгүй
5	BDL	Могойн гол ХК	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	Тодорхойгүй	Тодорхойгүй
6	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с	Тодорхойгүй
7	TAL	Талын гал ХК	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
8	AND	Анд-Энерги ХК	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
9	SUL	Жуулчин дюти фрий ХК	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с	Компанийн байранд
10	GTL	Гутал ХК	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с	Тодорхойгүй
11	BNG	Баянгол зочид буудал ХК	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с	Компанийн байранд
12	APU	АПУ ХК	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
13	BTG	Баянтээг ХК	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
14	MIE	Материалимпекс ХК	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
15	HRD	Хүрд ХК	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор	Тодорхойгүй
16	SUU	Сүү ХК	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
17	MNP	Монгол шуудан ХК	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
18	MMX	Махимпекс ХК	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с	Компанийн байранд
19	TCK	Талх чихэр ХК	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с	Компанийн байранд
20	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй	Тодорхойгүй
21	ADL	Адуун чулуун ХК	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	Тодорхойгүй	ҮЦТХТ-ийн данс
22	ТАН	Тахь-ко ХК	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
23	UBH	Улаанбаатар хивс ХК	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с	ҮЦТХТ-ийн данс
24	GOV	Говь ХК	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов	Компанийн байранд
25	HRM	Гермес центр ХК	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Эрдэнэ Ресурс Девелопмент”-ийн анхдагч зах зээлийн арилжааны захиалга нийлүүлэлтээсээ 64 хувиар давж хаагдлаа

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн анхны давхар бүртгэлтэй компани болох “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” нь нийт хувьцааны 2.7% буюу 3,898,900 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 15:00 цаг хүртэл авч дууслаа.

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”-ийн олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад 1,248 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 6,478,146 ширхэг худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнг даруй 64 хувиар давсан үзүүлэлт боллоо.

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”-ийн үнэт цаас худалдан авах захиалгуудыг хуваарилалтын төлөвлөгөөний дагуу биелүүлж, тайланг 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдөрт багтаан Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлсэн бөгөөд СЗХ-ноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож, хоёдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх шийдвэрийг гаргасан үед хөрөнгө оруулагч нар тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөрийн үлдэгдэл мөнгөн хөрөнгийг буцаан авах эрх үүсэх юм.

Мөн тус компани 2018 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс 6 дугаар сарын 08-ны өдрийн хооронд Канад улсад хаалттай хүрээнд 10,834,580 ширхэг нэмэлт хувьцааг тус бүрийг \$0.38 канад доллараар санал болгон худалдаалж, нийт 4.12 сая канад долларын хөрөнгийг амжилттай татан төвлөрүүлсэн тухай мэдээлсэн билээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



“Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2017 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 180611 тоот шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Хуралдах хугацаа: 2018.07.27, 14:00 цагт

Бүртгэх өдөр: 2018.07.02

Хуралдах газар: Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Корпорейт зочид буудлын хурлын танхимд хуралдана.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн дүрмийг батлах тухай;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
3. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулалын хэмжээг тогтоох.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Таван толгой” ХК-ийн 2017 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа

“Таван толгой” ХК-ийн 2017 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 2,410 төгрөг (татварын дараа 2,169 төгрөг) тараасныг 2018 оны 06 дугаар сарын 12-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

МИСС: Дотоодын хөрөнгийн зах зээлд урт хугацааны хөрөнгө оруулагч бага байна

Дотоодын хөрөнгийн зах зээлд урт хугацааны хөрөнгө оруулагч бага байгааг “МИСС” буюу Монголын Олон улсын хөрөнгө оруулалтын корпорацийн Гүйцэтгэх захирал онцоллоо. Урт хугацааны хөрөнгө оруулагч татахад санхүүгийн ил тод байдал хамгийн чухал байдаг байна.

Монгол Улсын хувьд сүүлийн үед гарсан IPO-уудын 80 хувийг иргэд, 20 хувийг гаднын хөрөнгө оруулалтын компаниуд авчээ. Харин олон улсын жишигт 80 хувийг байгууллага буюу урт хугацааны хөрөнгө оруулагчид авах хандлагатай байдаг байна.

Олон нийтээс санхүүжилт татан төвлөрүүлэхээр IPO гаргаж байгаа компаниудын санхүүгийн тайлан, санхүүжилтийн зорилгыг үнэн зөв гэдгийг мэргэжлийн компаниуд шалган батлах нь урт хугацааны хөрөнгө оруулагчдад чухал байдаг. Энэ утгаараа Санхүүгийн зохицуулах хороо эдгээр мэргэжлийн компаниудад тодорхой шалгуур тавьж байгаа талаар мэдээллээ.

Мөн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөж байгаа ч энэ нь чанарын биш тооны өсөлт гэдгийг тэрбээр онцолж байлаа. Цаашид дотоодын хөрөнгийн зах зээл илүү хөгжих боломжтой гэж Санхүүгийн зохицуулах хороо үзэж байна.

Түүнчлэн Монголын Хөрөнгийн биржийн гол зорилго бол урт хугацааны хөрөнгө оруулагчдыг татах гэж тус биржийн Хяналт зохицуулалтын газрын захирал мэдээллээ. Хэдийгээр Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын үйл ажиллагаа нь тогтвортой, санхүүгийн үзүүлэлтүүд нь эерэг боловч хувьцааны арилжаа нь идэвх багатай компаниуд олон байгааг Монголын Хөрөнгийн бирж онцолж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

ҮЦТХТ “Цахим аюулгүй байдлын мэдээлэл удирдлагын төв”-ийн гишүүнээр элслээ.

Монголын хөрөнгийн зах зээлд бүртгэгдсэн ХК-иудын үнэт цаас түүний бүртгэл, хадгалалтад цахим орчны аюулгүй байдал, хамгаалалтын асуудал чухлаар тавигдаж байна.

“ҮЦТХТ” ХХК-д хадгалагдаж буй үнэт цаас эзэмшигчдийн мэдээлэл түүний аюулгүй, найдвартай байдлыг хангах үүднээс “Цахим аюулгүй байдлын мэдээлэл удирдлагын төв” (MNCERT/CC)-ийн гишүүн байгууллагаар ҮЦТХТ ХХК 2018 оны 05 дугаар сарын 01-нд элсэн орлоо.

ҮЦТХТ нь тус байгууллагын гишүүнээр элссэнээр хортой код хуулагдсан Монгол улсад бүртгэлтэй хостуудын мэдээллийг өдөр тутам авах боломжтой болохоос гадна дэлхий даяар тархаж буй шинэ төрлийн халдлага, эмзэг байдал, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээний талаарх зөвлөмж, гарын авлага авах бүрэн боломжтой боллоо.

Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Эрдсийн экспорт 15%-иар өсч, нүүрс өсөлтөө хадгалав

Монгол улсын худалдааны эргэлт оны эхний таван сарын байдлаар 5.1 тэрбум ам.долларт хүрсэн байна. Энэ дунд экспорт 2.9 тэрбум ам.доллар, импорт 2.2 тэрбум ам.долларыг эзэлж байна. Тодруулбал нийт бараа эргэлт өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 26.5%, экспорт 15.1%, импорт 45.5%-иар тус тус өссөн дүнтэй гарч байна. Худалдааны ашиг 706.4 сая ам.долларт хүрсэн ч өмнөх оны мөн үеийнхээс 29.9%-иар буурсан байна.

Экспорт эхний таван сард өмнөх оны мөн үеийнхээс ийнхүү өсөхөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 371.9 сая ам.доллар, нэхмэл бүтээгдэхүүний экспорт 15 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.

Оны эхний таван сарын байдлаар эрдсийн экспорт 2.88 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 15.1%-иар давсан дүнтэй гарлаа. Үүнээс 39 хувийг буюу 1.1 тэрбум ам.долларыг нь нүүрсний экспорт бүрдүүлжээ.

Нүүрсний экспорт оны эхний таван сарын байдлаар 14.3 сая тоннд хүрсэн бөгөөд орлогын дүнгээр 1 тэрбум 110 сая ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад жингээр 5.1%-иар буурсан ч орлогын дүн 9.8%-иар өссөн байна. Харин сарын дүнгээр авч үзвэл өнгөрсөн тавдугаар сард дангаараа 3 сая 979 орчим мянган тонн нүүрс экспортолсон нь өмнөх дөрөвдүгээр сарынхаас 413 мянган тонн буюу 11.6%-иар өссөн байна. Өнгөрсөн оны зургадугаар сард сарын дүнгээр нүүрсний экспортын дээд амжилт (4059.7 мян.тн) тогтоогдсон байдаг. Тэгвэл өнгөрсөн тавдугаар сарын экспорт энэ дээд үзүүлэлтэд тун дөхөж очсоноороо хоёр дахь дээд амжилт боллоо.

Ийнхүү нүүрсний экспорт гуравдугаар сараас хойш сэргэсэн байна. Гол экспортлогч "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн төлөөлөгчид тавдугаар сард "Chalco" компанийн талтай уулзаж, нүүрсний үнээ 70 центээр нэмэгдүүлсэн аж. Одоо "Chalco"-д Зүүн Цанхийн нүүрсийг тонн тутмыг нь уурхайн амны нөхцөлөөр 60 ам.доллараар нийлүүлж байна.

Зэсийн баяжмалын хувьд мөн хугацаанд 601 мянган тонн бүтээгдэхүүн гадагш нийлүүлж, орлогын дүнгээр 823.3 сая ам.долларт хүрлээ. Энэ нь орлогын хувьд 30.2%-иар дээшилсэн бол жингийн хувьд адил түвшинд хадгалагдав. Мөн 100 орчим хувь БНХАУ-д экспортолжээ.

"Оюу Толгой" ХХК зэсийн баяжмалаа БНСУ, Японы зах зээлд гаргах боломжийг судалж эрэлхийлж байгаа талаар "Rio Tinto" мэдээлсэн байна. Тиймээс ойрын хугацаанд Монголын зэсийн баяжмалын зах зээл нэмэгдэж магадгүй байна.

Боловсруулсан цэвэр зэсийн хувьд эхний таван сарын байдлаар 5.8 мянган тонныг гадагш нийлүүлж, 39 сая орчим ам.доллар олсон нь жингээр 17.1%-иар буурсан ч орлого ижил түвшинд байна.

Боловсруулаагүй газрын тосны экспорт оны эхний таван сарын байдлаар 2.77 сая баррель буюу 177 сая ам.доллартай тэнцсэн нь жингийн хувьд 10.5%-иар буурсан ч орлогын хувьд 15%-иар нэмэгдсэн дүнтэй гарлаа.

Боловсруулаагүй алтны экспортын хувьд 3.4 тонныг гадагш нийлүүлж 144.5 орчим сая ам.доллар олсон нь жингийн хувьд 3%-иар буурсан ч орлогын хувьд 1.9%-иар дээшилсэн дүнтэй байгааг Үндэсний статистикийн хороо мэдээлсэн. Тэгвэл Монголбанкны мэдээлж буйгаар төв банкны алт худалдан авалтын дүн эхний таван сарын байдлаар 4.95 тоннд хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.5%-иар өсөөд байгаа юм.

Төмрийн хүдрийн тухайд 2.77 сая орчим тонныг гадагш нийлүүлж 131.2 сая ам.доллар олсон нь жингийн хувьд 24.3%-иар өссөн ч орлогын хувьд 5.7%-иар доошилсон дүн үзүүлжээ.

Цайрын хүдэр, баяжмалын экспортын тухайд мөн хугацаанд 52.3 мянган тоннд хүрч, орлогын дүн нь 92.8 орчим сая ам.доллар болсон нь биет жингээр 8.8%-иар дээшилж, үнийн дүн 28.3%-иар өссөн болохыг илтгэв. Жилд тогтмол 80 орчим мянган тонн цайрын баяжмал экспортолдог "Цайрт минерал" ХХК ханш цаашид буурах хандлагатай байгаа гэдгийг мэдээлсэн юм.

Жоншны баяжмалын хувьд мөн хугацаанд 153.4 мянган тонн хүдэр, баяжмалыг 50.6 сая ам.доллараар экспортолсон нь жингийн хувьд 37.4%, орлогын дүнгээр даруй 92.5%-иар тус тус дээшилснийг харууллаа.

Хар тугалгын хүдэр, баяжмалын экспорт мөн хугацаанд 7.7 мянган тоннд хүрч, 19.9 сая ам.долларт хүрсэн нь жингээр 23.8%, орлого 22.5%-иар өссөн дүнтэй гарлаа.

Молибденийн баяжмалын экспорт эхний таван сарын байдлаар 2.3 мянган тонн буюу 18.3 сая ам.долларт хүрсэн нь жингээр 8.5%-иар буурсан ч орлого 33.2%-иар өссөн болохыг харууллаа.

Гянтболдын хүдрийн экспортын тухайд эхний таван сарын байдлаар 127.9 тонныг экспортолж, 1.65 сая ам.доллар олсон нь жингээр 5.1%, орлого 33.8%-иар тус тус өссөн үзүүлэлттэй гарав.

Эх сурвалж: MongolianMiningJournal.mn, BloombergTv.mn



Petro Matad: Хаалттай хүрээнд хувьцаа гаргаж, 18.3 сая ам.долларын санхүүжилт татна

Лондоны Хөрөнгийн биржид бүртгэлтэй газрын тосны хайгуулын "Petro Matad" компани хаалттай хүрээнд хувьцаа гаргаж ойролцоогоор 18.3 сая ам.долларын санхүүжилт татахаар зорьж байгаа талаар мэдээллээ. Санхүүжилтийг 2019 онд өрөмдөх нэмэлт хоёр цооногийн ажилд зарцуулах юм байна. Ингэснээр тус компани энэ жилийн өрөмдөх дөрвөн цооногийг нэмж тооцоод ирэх 12 сарын хугацаанд нийт зургаан цооног өрөмдөх санхүүжилтийн бүрэн эх үүсвэртэй болж байгаа талаараа албан мэдэгдэлдээ онцолжээ.

Зургаан цооногийн таамаг нөөцийн хэмжээ ойролцоогоор 850 сая баррель байгаа юм байна. "Petro Matad" компани газрын тосны V блок дэх "Snow Leopard" талбайд хайгуулаа гүйцэтгэж дуусгахад шаардлагатай байгаль орчны зөвшөөрлөө авсан байна.

Өрөмдлөгийн ажлаа долоодугаар сард эхлэхээр төлөвлөжээ. Энэ талд БНХАУ-ын "Sinorec" компанитай хамтрахаар болсон юм байна.

Хаалттай хүрээнд хувьцаа гаргаж, санхүүжилт татна гэсэн энэхүү мэдээллийн дараа тус компанийн хувьцааны ханш Лондоны Хөрөнгийн биржид 0.4 хувиар өсөж, 12.85 пенст хүрээд байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

ҮСХ: Монголын эдийн засгийн 5-р сарын байдал

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2018 оны эхний 5 сард 3.3 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 3.3 их наяд төгрөгт хүрлээ.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2017 оны эхний 5 сард 412.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч байсан бол 2018 оны эхний 5 сард 45.4 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2018 оны эхний улиралд урьдчилсан гүйцэтгэлээр 348.1 сая америк долларын алдагдалтай гарч, алдагдал нь өмнөх оны мөн үеэс 218.4 сая америк доллараар өсжээ.

Урсгал данс 359.9 сая америк долларын алдагдалтай гарахад барааны тэнцэл 248.3 сая америк долларын ашигтай гарсан хэдий ч үйлчилгээний тэнцэл 364.9 сая америк доллар, анхдагч орлогын данс 298.1 сая америк долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгийн данс 2018 оны эхний улиралд 11.8 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 6.6 (36.1%) сая америк доллараар буурсан байна.

Санхүүгийн дансны тэнцэл 239.1 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 118.6 (98.5%) сая америк доллараар өсжээ.

Монгол Улс 2018 оны эхний 5 сард дэлхийн 131 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 5.1 тэрбум америк доллар, үүнээс экспорт 2.9 тэрбум америк доллар, импорт 2.2 тэрбум америк долларт хүрлээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.1 (26.5%) тэрбум америк доллар, үүнээс экспорт 379.3(15.1%) сая америк доллараар, импорт 681.1 (45.5%) сая америк доллараар тус тус өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2017 оны эхний 5 сард 1.0 тэрбум америк долларын ашигтай гарч байсан бол 2018 оны эхний 5 сард өмнөх оны мөн үеэс 301.8 (29.9%) сая америк доллараар буурч, 706.4 сая америк долларт хүрчээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 5 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.6 хувь, өмнөх оны эцсээс 4.5 хувь, өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.1 хувь (төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 32.8 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 5.2 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 10.1 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.4 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 4.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 13.8 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 22.2 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

Үүний зэрэгцээ иргэдийн хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг 70 хувиас хэтрүүлэхгүй байх хязгаар тогтоолоо.

Хэрэглээний зээлийн өсөлт нийт зээлийн өсөлтийн 80 гаруй хувийг эзэлж байгаа аж. Тиймээс иргэдэд учирч буй өрийн дарамтыг бууруулж, бизнесийн зээлийг дэмжих үүднээс иргэдийн хэрэглээний зээлийн өр орлогын харьцаанд хязгаарлалт тавьсан байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



Төгрөгийн хадгаламж өсөж, валютын хадгаламж буурчээ

Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр мөнгөний нийлүүлэлт 2018 оны тавдугаар сарын эцэст өмнөх оны мөн үеэс 31.2 хувиар өсөж, 17 их наяд төгрөгт хүрээд байна.

Мөнгөний нийлүүлэлт 30 гаруй хувиар өссөн нь эдийн засгийг дэмжихэд хангалттай хэмжээний өсөлт гэдгийг Монголбанкны судалгаа, статистикийн газрын захирал Д.Ган-Очир онцолж байгаа юм.

Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 801.6 тэрбум төгрөгөөр өсөхөд валютын харилцах 347.6 тэрбум төгрөг, төгрөгийн харилцах 310.8 тэрбум төгрөг, төгрөгийн хадгаламж 205.4 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Төгрөгийн ханш тогтвортой байгаа энэ үед валютын хадгаламж буурч, төгрөгийн хадгаламж өсөж байгаа дүр зураг ажиглагдаж байна. Тухайлбал, 2017 оны эцэст иргэдийн төгрөгийн хадгаламж 7.1 их наяд төгрөг байсан бол энэ оны дөрөвдүгээр сарын байдлаар 7.7 их наяд төгрөг болж өссөн байна. Харин иргэдийн валютын хадгаламж 2017 оны эцэст 1.9 их наяд төгрөгтэй тэнцэж байсан бол 2018 оны дөрөвдүгээр сард 1.8 их наяд төгрөг болж буурчээ. Санхүүгийн долларжилтыг бууруулах нь Монголбанкнаас боловсруулсан зээлийн хүүг бууруулах стратегийн нэг үндсэн зорилт юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээжгүй болно.